



2022 оны жилийн тайлан



"ЛэндМН ББСБ" ХК

Дэлхийн эн, Үнэнч сэтгэл, Эвийн хүч



Агуулга

“ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны
үйл ажиллагааны тайлан

- **Компанийн тухай**

 - 05 Эрхэм зорилго
Алсын хараа
Үнэт зүйлс
- **Бизнесийн үйл ажиллагаа**

 - 08 Мэндчилгээ
 - 10 Үйл ажиллагааны хураангуй
 - 11 Компанийн онцлох үйл явдал
 - 14 Зээлийн үйл ажиллагаа
 - 16 Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
 - 18 Хүний нөөц
- **Санхүүгийн тайлагнал**

 - 22 Аудитын дүгнэлт
 - 23 Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
Санхүү байдлын тайлан
 - 24 Мөнгөн гүйлгээний тайлан
Өмчийн өөрчлөлтийн тайлан
 - 25 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
- **Эрсдэлийн удирдлага**

 - 28 Эрсдэлийн удирдлага
- **Компанийн засаглал**

 - 32 Компанийн ерөнхий мэдээлэл
Компанийн засаглал
 - 33 “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
 - 34 Хувьцаа эзэмшигчдийн хурал
 - 35 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
 - 36 ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа
 - 39 Дотоод аудит
 - 40 Компанийн бүтэц, зохион байгуулалт
 - 42 Удирдлагын баг
 - 43 Хувьцааны мэдээлэл
Ногдол ашгийн мэдээлэл

Компанийн тухай

Дэлхийн эн,
Үнэнч сэтгэл,
Эвийн хүч

Эрхэм зорилго

Хиймэл оюун ухаанд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ санхүүгийн салбарт шинэ жишиг тогтоогч таны АНД байна.



Алсын хараа

Дэлхийн энтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ Монголын санхүүгийн зах зээлд манлайлна.



Үнэт зүйлс

Инноваци, хурд, хариуцлага, мэргэшсэн өндөр чадвар, зогсолтгүй суралцах зарчим, хүн төвт зарчим



**Өөртөө зориулах цагийг
өөрт тань үлдээе!**




Бизнесийн үйл ажиллагаа

- Мэндчилгээ
- Үйл ажиллагааны хураангуй
- Компанийн онцлох үйл явдал
- Зээлийн үйл ажиллагаа
- Компанийн нийгэмд үзүүлсэн үр нөлөө
- Хүний нөөц

"ЛэндМН ББСБ" ХК

Дэлхийн эн, Үнэнч сэтгэл, Эвийн хүч



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн эрхэм хүндэт харилцагчид, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, бизнесийн түнш болон хамтрагч байгууллагууд та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

“ЛэндМН ББСБ” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа өөрийн харилцагч, хөрөнгө оруулагч, бизнесийн түнш, хамтрагч нараа эрхэмлэн бүгдэд хүртээлтэй хамтын үнэ цэнэ үүсгэх зорилгоор ирээдүйд чиглэсэн технологи, бизнесийн инновацлаг шийдлийг тасралтгүй санаачлан ажиллаж байна. Бидний хамтын хүчээр “ЛэндМН ББСБ” ХК нь өнгөрөгч 2022 онд бизнесийн хувьд өндөр өсөлтийг үзүүлж ажиллалаа. Хамтын амжилтын талаарх үйл ажиллагааны тайланг та бүгдэд хүргэж буйдаа таатай байна. Та бүхэн энэхүү тайлантай тухлан танилцаж аливаа шүүмж, зөвлөмжөө харамгүй хуваалцахыг хичээнгүйлэн хүсье.

Инновац, нээлттэй хамтын ажиллагааг идэвхжүүлж хамтын үнэ цэнийг бүтээнэ.

Өнөөдрийн “ЛэндМН ББСБ” ХК нь инновац, хамтын ажиллагааны үр дүнд үйлчилгээгээ харилцагчдадаа тасралтгүй хүргэж байна. 2023 онд бид өөрсдийн үнэт зүйл болсон инновац, нээлттэй хамтын ажиллагааг дараагийн түвшинд хүргэж үсрэнгүй өсөлтийг үзүүлэхээр ажиллаж байна. Энэхүү эрхэм зорилгын хүрээнд бид эрч хүч, өндөр ур чадвар, арвин туршлага бүхий авьяаслаг мэргэжилтнүүдээр бүл нэмж, удирдлагын багтаа хүч нэмж буй бөгөөд эдгээрээс хамгийн онцлох хүн бол ЛэндМН-ийн Ерөнхийлөгчөөр томилогдсон, санхүүгийн салбарын арвин их туршлагатай Кацухико Мадоно юм. Тэрээр Тайланд улсад Easy Buy компанийг 12 жил манлайлан ажиллахдаа 83 салбар, 1,500 гаруй ажилтантай, 750 сая ам.долларын зээлийн багц болон 200 сая ам.долларын орлоготой томоохон компани болгон хөгжүүлсэн.

“ЛэндМН ББСБ” ХК нь дэлхий дахинд өрнөж буй технологийн хурдацтай хөгжилд үндэслэн нийт харилцагч, хөрөнгө оруулагч, бизнесийн түнш, хамтрагч нартаа үнэ цэнийг бүтээн ажиллахыг зорьж байна. Энэ зорилгод хүрэхэд та бүгдийн дэмжлэг, хамтын ажиллагаа суурь болох учир та бүхнийг “ЛэндМН ББСБ” ХК-ийг дэмжин ажиллахыг хүсье.

Хүндэтгэсэн:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал
Цэрэндорж Ууганбаяр



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт харилцагчид, хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, бизнесийн түнш болон хамтрагч байгууллагууд та бүхэн маань сайхан хаваржиж байна уу.

Кацухико Мадоно миний бие 2020 оноос эхлэн ЛэндМН-ийн толгой компани болох АНД ГЛОБАЛ компанийн чадварлаг, эрч хүчтэй хамт олонд нэгдэн ажиллаж байгаа бөгөөд ЛэндМН-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх захирлын зүгээс итгэл хүлээлгэж, 2023 оноос эхлэн ЛэндМН-ийн удирдлагын багт ажиллах боломж олгосон нь миний хувьд туйлын хүндэтгэлтэй хэрэг билээ.

АНД ГЛОБАЛ компанид анх нэгдэж, түүний компаниуд болон хэрэгжүүлж буй төсөлтэй танилцаж байхад маш богино хугацаанд инновац бүхий технологийн шийдлийг санхүүгийн үйлчилгээтэй уялдуулж, амжилттай хэрэгжүүлэн олон улсад жишиг болон яригдаж буйгаараа сэтгэлд минь тодхон үлдсэн ЛэндМН-ийн нэг хэсэг болсон нь миний ажил, амьдралд ховорхон тохиох аз завшаан юм.

“Зүүн Өмнөд Азид хэрэгжүүлж буй технологийн шийдэлд тулгуурласан зээлийн үйлчилгээний төслүүдийг 41 жилийн хугацаанд удирдан ажиллаж ирлээ”

Миний бие өмнө нь Япон, Тайланд, Филиппин зэрэг улсуудын банк, санхүүгийн салбарт тасралтгүй 41 жилийн хугацаанд иргэдэд зориулсан санхүү, зээлийн үйлчилгээг хөгжүүлэх чиглэлээр голчлон ажиллаж, АСОМ, ИТОСНУ, АИФУЛ зэрэг Япон улсын томоохон санхүүгийн групп компаниудаас Зүүн Өмнөд Азид хэрэгжүүлж буй технологийн шийдэлд тулгуурласан зээлийн үйлчилгээний төслүүдийг удирдан гүйцэтгэх захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, мөн зөвлөхөөр ажиллаж байв.

Тухайлбал, Тайланд улсын томоохон санхүүгийн байгууллагын нэг болсон EASY BUY компанийг 1996 онд үүсгэн байгуулалцаж, 1998-2009 оны хооронд Гүйцэтгэх захирлын үүргийг гүйцэтгэж байв. Ийнхүү анх 45 ажилтантай эхэлж байсан EASY BUY компани нь 2010 он гэхэд Тайланд улс даяар 83 салбар болон 1,500 гаруй ажилтантай, 750 сая ам.долларын зээлийн багц болон 200 сая ам.долларын орлоготой томоохон компани болж өргөжсөн юм. Мөн Тайланд улсын санхүүгийн зах зээлд технологийн шийдэлд тулгуурласан зээлийн үйлчилгээ үзүүлэгч AIRA & AI-FUL компанийг үүсгэн байгуулалцаж, анхны гүйцэтгэх захирлаар 2014-2019 оны хооронд ажилласан туршлагатай.

“ЛэндМН-ийн хөгжлийг дараагийн түвшинд гаргахад чин сэтгэлээсээ хичээнгүйлэн ажиллаж, өөрийн мэдлэг туршлагыг бүрэн зориулах болно”

Миний бие банк, санхүүгийн салбарт ажиллах хугацаанд бизнесийн стратеги, брэндинг, маркетинг, хүний нөөцийн хөгжил, менежмент, мэдээллийн технологийн системийн стратеги зэрэг чиглэлээр өргөн хүрээний мэдлэг туршлага хуримтлуулсан юм.



Миний зүгээс 2023 онд ЛэндМН-ийг хөгжлийн дараагийн түвшинд гаргах цогц бодлогуудыг хэрэгжүүлэхэд гар бие оролцож, харилцагчдадаа хамгийн таатай бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэн хүргэх, улмаар санхүүгийн зах зээлийн түүчээлэгч, олон улсын үнэ цэнтэй компани болгон хөгжүүлэхэд чин сэтгэлээсээ хичээнгүйлэн ажиллаж, өөрийн хуримтлуулсан мэдлэг туршлагыг бүрэн зориулах болно гэдгээ илэрхийлмээр байна.

Хүндэтгэсэн:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ерөнхийлөгч

Кацухико Мадоно

2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ



2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ


Lendzээл – Ашигласан хугацаагаараа хүүгээ төлдөг боллоо.



■ ЛэндМН нь 21 аймаг, 9 дүүрэгт гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэн ажилласан төдийгүй хэрэглээний зээлийн үйлчилгээ ашигласан хугацаагаараа хүүгээ төлдөг болсон юм.

■ Харилцагчид маань LendMN аппликейшнээр дамжуулан автоматаар зээлийн эрхээ тогтоолгож, эко автомашинууд болох /Toyota Aqua, Prius 30, Prius 40, Prius 41, Sai/ хабрид автомашинуудыг зээлээр авах боломжийг бүрдүүлсэн нь бусад банк бус санхүүгийн байгууллагуудаас онцлогтой хялбар үйлчилгээ боллоо.

■ ЛэндМН-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ илүү өргөжиж, бүтээгдэхүүний төрөл нэмэгдсэн бөгөөд мөнгөн хөрөнгөө өсгөх олон боломжуудтай “Хөрөнгө оруулалт” цэс шинэчлэгдлээ.




■ ЛэндМН нь Мэдээллийн Аюулгүй Байдлын Менежментийн Тогтолцоо ISO/IEC 27001:2013 олон улсын стандартад нийцэн, 2022 онд баталгаажуулалтын аудит хийлгэж, албан ёсоор баталгаажуулалтын гэрчилгээг хүлээн авлаа. ЛэндМН нь Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэнээр харилцагчийн мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байгаагийн нэг илрэл боллоо.



■ Компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ мөнгөн хэлбэрээр хуваариллаа.



■ 2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа. Хурлыг компанийн фэйсбүүк пэйж хуудсаар шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд энэхүү хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.28% нь оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлуудыг хэлэлцэн баталлаа.



■ “ЛэндМН ББСБ” ХК-ийн охин компани “ЛэндМН Актив ТЗК” ХХК нь 2022 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрлөө авч, улмаар 4.85 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүллээ. Мөн Лэнд ХБҮЦ нь сар бүр өгөөж хуваарилах нөхцөлтэй арилжаалагдсан ба нийт хөрөнгө оруулагчдын хуваарьт өгөөжийг 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд байршуулсан юм.



■ “ЛэндБонд”-ын Транч II-ын анхдагч зах зээлийн арилжаа 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгуулагдаж нийт 188 хөрөнгө оруулагчдаас 3.1 тэрбум төгрөгийг арилжаа зарлагдсан хугацаанаас өмнө татан төвлөрүүлж, анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдаж, 2 удаагийн Транчаар буюу 2021 онд 2.5 тэрбум, 2022 онд 3.1 тэрбум нийт 5.6 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүллээ.

2022 онд арилжаалагдсан “Лэндбонд”-ийн өгөөжүүд үнэт цаасны дансанд хугацаандаа тус тус байршлаа.



■ МББСБХ-оос гишүүн байгууллагуудаа уриалж Санхүүгийн зохицуулах хороо, Банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтарч “Монгол Улсад нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлж, ногоон зээлийг дэмжихийн төлөөх хамтарсан тунхаг бичиг”-ийг байгууллаа.



■ “Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо” “ЛэндМН ББСБ” ХК хамтран зохион байгуулсан Сагсан Бөмбөгийн Аварга Шалгаруулах 8 Дахь Удаагийн “We Care Tomorrow” уриатай ТЭМЦЭЭН 2022 оны 05 сарын 14-15-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулагдаж, нөхөрсөг гал гарсан өрсөлдөөнтэй, сонирхолтой, тоглолтуудаар дүүрэн болж аваргуудаа шалгарууллаа.



■ Монгол улс Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” төслийг ЛэндМН дэмжин “Санхүүгийн зохицуулах хороо”-нд мод тарих үүрэг амлалтаа хүргүүллээ. ЛэндМН нь байгаль орчинд ээлтэй төсөл хөтөлбөр, ногоон санхүүжилтийг дэмжин ажиллахаар боллоо.



ЛэндМН нь ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгод ажлуудад нийгмийн хариуцлагынхаа хүрээнд идэвх чармайлттай оролцохыг зорьж ажилладгийн хувьд Монголын ББСБ-ын нэрэмжит “ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН”-ийн шав тавих их үйлсэд нэгдэж хамт олноороо Гачууртын Минж үржүүлгийн газарт мод тариллаа.



Мөн хамт олноороо Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар болон Ургуулахад учир бий клубтэй хамтран Чингэлтэй дүүргийн Хайрхан Хөгжлийн Төвд 150 ширхэг мод тарьсан.



■ “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр ШангриЛа Улаанбаатарт “IPO MONGOLIA-2022” форумыг “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо”-той хамтран зохион байгууллаа. Тус форумын Ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажиллалаа.




ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2022 онд LendMN аппликейшнээр дамжуулан харилцагч нартаа нийт 561.8 тэрбум төгрөгийн дүнтэй 2,650 мянган зээлийг олгосон байна. Зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2021 онтой харьцуулахад гэрээт харилцагчдын тоо 7%, олгосон зээлийн тоо 37%, олгосон зээлийн дүн

48%, зээлийн багц 110%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлт нь ЛэндМН-ийн зээлийн үйл ажиллагаа улам бүр тэлж байгааг илэрхийлэх бөгөөд зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр 7 жилийн түүхэнд хамгийн дээд хэмжээнд хүрсэн амжилттайгаар ажиллалаа.


Гэрээт харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянга/




Бүртгэлтэй харилцагчийн тоо

/Өссөн дүнгээр, мянга/




Зээлийн багц

/Тэрбум төгрөг/




Харилцагчид

байршлаар




Олгосон зээлийн дүн

/Тэрбум төгрөг/



Олгосон зээлийн тоо

/Мянган зээл/




Зээлийн багцын чанарын үзүүлэлт

2022 онд зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2021 оны жилийн эцсээс 22.4%-иар буурч 4.0% хүрсэн ба зээлийн

эрсдэлийн сангийн нөөц 3.3 тэрбум төгрөг буюу зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 115.7% хүргэж ажиллалаа.

Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь



КОМПАНИЙН НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ҮР НӨЛӨӨ



ЛэндМН нь санхүүгийн хүртээмжтэй байдлыг хүн бүрд хүргэх зорилгоор:

Технологийн дэвшлийг ашиглан Улаанбаатар хотод **1 салбартайгаар**, харилцагчдадаа цахимаар зээлийн үйлчилгээг үзүүлэн **Монгол улсын өнцөг булан бүрд хүрч үйлчилж байна.**

Харилцагч бүрийн санхүүгийн асуудлыг шийдэхийн тулд зөвхөн **тогтмол цалингийн орлоготой** харилцагчдад зээл олгох бус **тогтмол орлогын эх үүсвэртэй** харилцагчдад зээл олгох боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

■ Харилцагчийн үйлчилгээний төв нь хэрэглэгчдэд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэн 2022 онд нийт **423,160 дуудлага хүлээн авч**, сошиал суваг болон үйлчилгээний заалаар дамжуулан **94,008 хэрэглэгчдэд** үйлчлэн ажилласан байна.

■ 2022 онд нэг хэрэглэгч зээл авахад хамгийн багадаа **3 цаг зарцуулдаг** гэж үзвэл бид цахимаар хамгийн шуурхай зээлийн үйлчилгээг үзүүлснээр **196.5 мянган** харилцагчийн зээл авахад зарцуулах **590 мянган цаг** буюу **67 жилтэй** тэнцэх хэмжээний хугацааг хэмнэх боломжийг олгожээ.

■ Нэг удаагийн зээл олголтод дунджаар **15 хуудас цаас** зарцуулдаг. Бид **2,7 сая** удаагийн зээлийг цахим хэлбэрээр баримт бүрдүүлэхгүй олгосноор **106.5тонн цаас** хэмнэж **2,500 ширхэг мод** аварчээ.

■ Барьцаагүй зээлийн үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчдийн **207 тэрбум төгрөгийн** эд хөрөнгө, нэр хүндээ барьцаалах үйлдлээс сэргийлж, барьцаа хөрөнгийн асуудлыг бүрэн шийдвэрлэлээ.

Компанийн хөрөнгө оруулагчдад төлсөн нийт хүү

3.9

тэрбум төгрөг

Аж ахуй нэгжийн орлогын албан татварт төлсөн дүн

1.0

тэрбум төгрөг

Нийгмийн даатгалын шимтгэлд байгууллагаас | ажилтнуудаас

297.8 | **243.3**

сая төгрөг

Гуравдагч этгээдээс авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт

Худалдан авалт болон хамтын ажиллагаа

3.0

тэрбум төгрөг

Хандив тусламж

14

сая төгрөг

ХҮНИЙ НӨӨЦ



ЛэндМН Дүр төрх



Хариуцлагатай

Хурдтай

Үр бүтээлтэй

Тасралтгүй суралцагч

Шинийг санаачлагч

Хүнлэг

Эрүүл мэнддээ анхаардаг

Спортлог



Манай хамт олон

Компанийн
нийт ажилтнуудын тоо

97

Үндсэн ажилтан

85¹²

Гэрээт болон цагийн ажилтан

Дундаж нас

31



Эрэгтэй

32%

Эмэгтэй

68%

- **Цалин:** 2022 онд ковид цар тахал, эдийн засгийн нөхцөл байдлаас үл хамааран нийт ажилтнуудын цалинг 10.4%-аар нэмэгдүүллээ.
- **Эрүүл мэндийн даатгал:** Манай байгууллага "МИГ" даатгалын компанийн эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд ажилтнуудаа хамруулж урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа.
- **Уян хатан нөхцөл:** Ажлын байрны уян хатан цагийн нөхцөлийг үргэлжлүүлэн, ажил амьдралын балансыг сайжруулах тал дээр анхаарч ажиллалаа.
- **Mentorship:** Ажилтнуудынхаа хувийн хөгжил, мэдлэг боловсролыг сайжруулахтай холбоотойгоор удирдлагын "1 on 1 Mentorship" хөтөлбөрийг зохион байгууллаа.
- **Өглөөний цай:** Бид ажилтнууддаа зориулан "Өглөөний цай" хөтөлбөрийг үргэлжлүүлэн ажиллалаа.
- **Чөлөөт цаг:** Бидний ажлын байранд дартс, шатар болон ширээний теннис амралтын танхимд байрлах ба хамт олны хүсэл сонирхлын үүднээс спорт арга хэмжээг тогтмол зохион байгуулж ажиллалаа.

**Хэзээ ч, Хаанаас ч санхүүгийн
асуудлаа шийдээрэй.**



Санхүүгийн тайлагнал

- Аудитын дүгнэлт
- Орлого, үр дүнгийн хураангуй тайлан
- Санхүү байдлын тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

"ЛэндМН ББСБ" ХК

Дэлхийн эн, Үнэнч сэтгэл, Эвийн хүч

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компанийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдлын хураангуй тайлан болон тухайн жилийн нэгтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлангаас бүрдсэн Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг ЛэндМН ББСБ ХК ("Компани") болон түүний охин компани (хамтад нь "Групп" гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу Группийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлантай тохирч байна.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлан нь Группийн СТОУС-ын дагуу бэлтгэсэн аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг орлохгүй.

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан ба аудиторын дүгнэлт

Бид 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдөр батлагдсан аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад зөрчилгүй дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд доорх хэсэг багтсан.

- Аудитын онцгойлсон асуудал - Аудитын онцгойлсон асуудал нь тухайн жилийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудал болох "Харилцагчдад олгосон зээл болон урьдчилганы үнэ цэнийн бууралт" байсан.

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайлантай холбоотойгоор удирдлагын хүлээх хариуцлага

Нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланг "Тайлан бэлтгэх үндэслэл" тодруулгад тайлбарласны дагуу бэлтгэх нь Группийн удирдлагын хариуцлага юм.


Аудиторын хариуцлага

Бидний үүрэг бол шинэчлэгдсэн Аудитын Олон Улсын Стандарт ("АУОС") 810 буюу "Санхүүгийн Хураангуй Тайлангийн Талаар Дүгнэлт Өгөх Гэрээт Ажил"-ын дагуу шаардсан горимуудыг гүйцэтгэж, түүндээ үндэслэн нэгтгэсэн санхүүгийн хураангуй тайланд дүгнэлт өгөх явдал юм.

Ernst & Young Mongolia Audit LLC

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан


Мандахбаяр Доржбат
Партнер

Баталсан


Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 2 дугаар сарын 6

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /Нэгтгэсэн/

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан /тэрбум төгрөг/	2020 /аудитлагдсан/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/
Нийт орлого	16.37	12.49	20.22
Хүүгийн зардал	(4.72)	(2.80)	(3.95)
Цэвэр орлого	11.65	9.69	16.27
Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал	(2.36)	0.73	(1.44)
Үйл ажиллагааны цэвэр орлого	9.29	10.42	14.83
Удирдлагын болон ҮА-ны зардал	(6.54)	(5.95)	(8.29)
Татварын өмнөх ашиг	2.75	4.47	6.53
Татварын зардал	(0.32)	(0.47)	(1.01)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр ашиг	2.43	4.00	5.53
Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)	-	(0.11)	-
Цэвэр ашиг	2.43	3.89	5.53

Санхүү байдлын тайлан /Нэгтгэсэн/

Хөрөнгө /тэрбум төгрөг/	2020 /аудитлагдсан/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	10.35	4.90	5.22
Зээлийн багц (цэвэр)	25.43	32.43	69.59
Бусад хөрөнгө	3.44	0.77	1.06
Үндсэн хөрөнгө	1.11	0.76	0.59
Биет бус хөрөнгө	0.40	0.45	0.40
Нийт хөрөнгө	40.73	39.31	76.86

Өр төлбөр болон эздийн өмч /тэрбум төгрөг/

Өр төлбөр	23.02	19.49	52.63
Эх үүсвэр	21.11	15.07	45.96
Хоёрдогч өглөг	-	2.95	2.95
Бусад өглөг	1.91	1.47	3.72
Эздийн өмчийн дүн	17.71	19.82	24.23
Хувьцаат капитал	9.82	8.48	8.48
Хуримтлагдсан ашиг	7.89	11.34	15.75
Нийт өр төлбөр болон эздийн өмч	40.73	39.31	76.86

Мөнгөн гүйлгээний тайлан /Нэгтгэсэн/

Мөнгөн гүйлгээний тайлан /тэрбум төгрөг/	2020 /аудитлагдсан/	2021 /аудитлагдсан/	2022 /аудитлагдсан/
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	28.43	(0.88)	(28.48)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(0.42)	0.98	(0.28)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(19.93)	(4.70)	29.08
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт	8.08	(4.60)	0.32
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1.42	9.50	4.90
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9.50	4.90	5.22

Өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн өөрчлөлтийн тайлан /тэрбум төгрөг/	Хувьцаат капитал	Халаасны хувьцаа	Бусад нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт эздийн өмч
2020.01.01-ний өдрийн байдлаар	10.76	(0.27)	0.06	6.65	17.20
Тайлант жилийн цэвэр ашиг				2.43	2.43
Ноогдол ашиг				(1.19)	(1.19)
Халаасны хувьцаа		(0.72)			(0.72)
2020.12.31-ний өдрийн байдлаар	10.76	(0.99)	0.06	7.89	17.71
Тайлант жилийн цэвэр ашиг				3.89	3.89
Ноогдол ашиг				(0.44)	(0.44)
Халаасны хувьцааны цэвэр худалдан авалт		(1.35)			(1.35)
2021.12.31-ний өдрөөр байдлаар	10.76	(2.34)	0.06	11.34	19.81
Тайлант жилийн цэвэр ашиг				5.52	5.52
Ноогдол ашиг				(1.11)	(1.11)
Халаасны хувьцааны цэвэр худалдан авалт		-			
2022.12.31-ний өдрийн байдлаар	10.76	(2.34)	0.06	15.75	24.22

Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

Цар тахлын дараах бизнесийн үйл ажиллагаа сэргэж 2021 оны эцэст нийт багцад эзлэх чанаргүй зээлийн түвшин 5.2%-иас буурч 2022 оны 4-р улирлын байдлаар 4.0%-д хүрсэн эерэг үзүүлэлттэй байна.

“ЛэндМН ББСБ” ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д заасны дагуу 2022 оны жилийн эцэст 1.86 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан

байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-н стандартын дагуу 3.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь Санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 115.7%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлаар компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд 2022 онд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласныг доорх хүснэгтээс харна уу.

Харьцаа үзүүлэлтүүд	Байвал зохих	2020	2021	2022
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-иас доошгүй	52.1%	48.6%	28.1%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-иас доошгүй	52.1%	55.5%	31.5%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-иас доошгүй	46%	50.3%	31.5%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-иас дээш	43.2%	29.4%	12.0%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	0.5%	(11.09%)	(39.8%)
Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-иас хэтрэхгүй	55.2%	33.5%	78.5%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-иас хэтрэхгүй	38.7%	32.3%	38.0%

**Бид харилцагчдадаа найдвартай,
хариуцлагатайгаар бүтээгдэхүүн,
үйлчилгээгээ хүргэхийг эрхэм болгодог.**



 **lendmn**

Эрсдэлийн удирдлага

"ЛэндМН ББСБ" ХК

Дэлхийн эн, Үнэнч сэтгэл, Эвийн хүч

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“ЛэндМН ББСБ” ХК нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаас гаргагч нээлттэй компанийн хувьд хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, хувь нийлүүлэгч болон харилцагчдынхаа итгэлийг хүлээж бизнесийн ёс зүйг эрхэмлэн ажилладаг шинэ үеийн жишиг болох сайн засаглалын хүрээнд Эрсдэлийн Удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлж ажилласаар ирлээ.

Манай байгууллага нь Дотоод Хяналтын бодлогоор дамжуулан хууль тогтоомж, дотоод болон гадаад дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийн нийцэл, санхүүгийн үнэн зөв тайлагнал, үндсэн үйл ажиллагааны үр дүнтэй байдал болон үр ашгийг нэмэгдүүлж урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна. Нийт ажилтнуудыг хамруулсан болон нэгжийн ажил үүрэгтэй уялдсан “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, “Дотоод хяналтын бодлого”-н сургалтыг дотоодын цахим платформын хэрэглээг дэмжин онлайн хэлбэрээр зохион байгуулж эрсдэлийн менежментийн оролцоог нэмэгдүүлж нэгдсэн мэдээллээр хангаж ажиллалаа.

Тайлант хугацаанд Үйл ажиллагааны эрсдэлийн гадаад болон дотоод орчны хүчин зүйлсийг улирал тутам шинэчлэн үнэлж алба нэгжүүдэд эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, холбогдох журам заавраар хангахын сацуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороонд тайлагнаж ажилласнаар Эрсдэлийн удирдлагыг үр

дүнтэй хэрэгжүүлэх, засаглалыг тасралтгүй сайжруулах үндсэн зорилгыг хэрэгжүүлсэн байна.

Зохицуулагч байгууллагаас гаргасан тогтоол, мэдэгдэл, журмын шинэчлэлийг цаг алдалгүй үйл ажиллагаандаа нийцүүлэн ажиллах зарчмын хүрээнд холбогдох журмуудыг дотоод үйл ажиллагаа болон хуулийн шаардлагад нийцүүлэн шинэчлэн баталж, мөн үйл ажиллагаанд шаардлагатай шинэ журмыг боловсруулж ажилласан. Жишээ болгон дурдвал: “Ялгаварлал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх журам”, “МАБМТ-ын аудитын журам”, “Мэдээлэл технологийн өөрчлөлтийн удирдлагын журам”, “Мэдээллийн ил тод байдлын тухай журам”-г шинээр боловсруулсан.

Комплаенсийн эрсдэлийн удирдлагын хүрээнд “Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр”, Санхүүгийн зохицуулах хорооны 160 тоот тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагааны журам” батлагдсантай холбоотой “Зээлийн үйл ажиллагааны журам”-г болон “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Нууцлалын журам”, “Мэдээлэл технологийн дэд бүтцийн журам”, “Харилцагчийг таньж мэдэх, төлбөр тооцооны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааны журам”, “Биет бус мэдээллийг нөөцлөх, нөхөн сэргээх журам” болон бусад журмыг тухай бүр шинэчлэн үйл ажиллагаандаа нийцүүлэн баталж ажилласан байна.

ЛэндМН-ийн голлох эрсдэлүүд

Гол эрсдэлүүд	Эрсдэлийн үйл явдал, үр дагавар, нөлөөлөл	Эрсдэлийн удирдлагын хэрэгжилт
Зах зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн алдагдал хүлээх; - Эх үүсвэр болон активын хүүгийн зөрүүгээс санхүүгийн алдагдал хүлээх; 	<ul style="list-style-type: none"> - Гадаад валютын нээлттэй позицийг зохистой түвшинд барин ажиллав. - Эх үүсвэр, активын удирдлагыг оновчтой хэрэгжүүлсэн. - Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзлийг тооцон ажиллав.
Санхүүгийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Зохистой харьцааны үзүүлэлт алдагдах; - Төлбөрийн чадвар алдагдах буюу хөрөнгө оруулагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох; - Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох; - Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах; 	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөлт хангалттай хэрэгжүүлсэн. - Тогтмол тайлагналт хийж байв. - Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн. - Эх үүсвэрийн төвлөрлийг удирдсан. - Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулсан бодлого чиглэл баримталж ажиллаа.
Зээлийн эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Зээлийн багцын чанар буурах; - Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх; - Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх; 	<ul style="list-style-type: none"> - Компанийн дотоод бодлого, журам, бүтээгдэхүүний нөхцөлийг шинэчлэн баталлаа. - Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлалыг дахин шинэчлэв.
Үйл ажиллагааны эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Биет эд хөрөнгийн зардал; - Бизнесийн үйл ажиллагааны тасалдал; - Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал); - Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй нэр хүндийн гэх мэт); 	<ul style="list-style-type: none"> - Дотоод бодлого, журам, зааврыг шинэчлэв. - Дотоод хяналтын хэрэгжилтийг ханган ажиллалаа. - Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц гадаад, дотоод эрсдэлийг үнэллээ.
Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах; - Мэдээллийн бааз гэмтэх, устах, мэдээлэлд хандах боломжгүй болох; - Системийн эмзэг байдлыг ашиглах; 	<ul style="list-style-type: none"> - ISO 27001:2013 мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэн ажиллаа. - Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг хэрэгжүүлж, түүнтэй холбоотой журмуудыг шинэчлэн баталлаа. - Системийн эмзэг байдал, цахим халдлага зэрэг эрсдэлээс урьдчилан сэргийлж тогтмол аюулгүй байдлын тест явуулж ажиллаа.
Байгаль орчин, нийгмийн хариуцлага	<ul style="list-style-type: none"> - Финтек чиглэлээр санхүүгийн үйлчилгээ зөвхөн иргэдэд үзүүлдэг. Тус үйл ажиллагааг явуулахад байгаль орчинд нөлөөлөх эрсдэл бусад салбартай харьцуулбал харьцангуй бага тул байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг гэж хэлж болно. 	<ul style="list-style-type: none"> - Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ гаргахдаа хууль, хянан нийцүүлэлт болон байгаль орчин нийгэмд эрсдэлтэй эсэхийг харгалзан үзэж шийдвэр гаргадаг. - Байгаль орчинд ээлтэй эко автомашины зээл гаргав.



**ЛэндМН нь бол Монголын хамгийн
анхны финтек компани юм.**



Компанийн засаглал

- Компанийн ерөнхий мэдээлэл
- Компанийн засаглал
- "Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ
- Хувьцаа эзэмшигчдийн хурал
- Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн
- ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа
- Дотоод аудит
- Компанийн бүтэц, зохион байгуулалт
- Удирдлагын баг
- Хувьцааны мэдээлэл
- Ногдол ашгийн мэдээлэл

"ЛэндМН ББСБ" ХК

Дэлхийн эн, Үнэнч сэтгэл, Эвийн хүч

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Оноосон нэр: "ЛэндМН ББСБ"	МХБ-ийн хувьцааны бүртгэлийн ангилал: I ангилал
Хэлбэр: Нээлттэй хувьцаат компани	Гаргасан нийт хувьцааны тоо ширхэг: 800,000,000
Регистрийн дугаар: 5039754	Нийт хувьцаа эзэмшигчдийн тоо: 5474
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллага: Монголын хөрөнгийн бирж	Үндсэн үйл ажиллагааны чиглэл: Зээлийн үйл ажиллагаа

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

"ЛэндМН ББСБ" ХК нь Монгол Улсын хууль тогтоомж болон Монголын хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй, нээлттэй хувьцаат компани болохынхоо хувьд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, түүнчлэн Монголбанкны холбогдох журам, засаглалын дүрэм, кодексыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

"ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани") нь зохистой засаглал, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангахад онцгойлон анхаарч, улмаар удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөл, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын хоорондох цогц харилцааг төгөлдөржүүлэх, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн урт хугацаанд тогтвортой үнэ цэнийг бий болгохыг үргэлж зорьсоор ирсэн юм.

Манай Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, оролцогч талуудтай үр дүнтэй холбоо үүсгэх, санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөв, цаг алдалгүй хүргэх зорилгоор

үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн талаар улирал бүрийг болон хагас жилийн хугацааг хамруулан мэдээлэх стратегийг баримталж, нийт 5 удаагийн тайлан гарган олон нийтэд хүргээд байна.

Ийнхүү 2022 оны I улирлын тайланг 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдөр, II улирлын тайланг 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр, III улирлын тайланг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдөр, IV улирлын тайланг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр болон эхний хагас жилийн тайланг 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр тус тус гарган олон нийтэд мэдээлснээр Компанийн бизнес, засаглал, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвийн талаарх мэдээллийг тухай бүр авах боломжийг хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, харилцагчид болон оролцогч талуудад олгож, харилцан итгэлцэл, эргэх холбоо бүхий хамтын ажиллагааг бий болгосон юм.

Түүнчлэн, Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр болон төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоолыг тухай бүр олон нийтэд нээлттэй мэдээлэн ажиллалаа.

"Компанийн засаглалын кодекс"-ын хэрэгжилт, түүний үнэлгээ

Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 03 дугаар сарын 23-ний өдрийн 145 тоот тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ыг үйл ажиллагаандаа даган мөрдөж, хэрэгжүүлэн ажилласан бөгөөд нэгдсэн үнэлгээний хүрээнд дараах үзүүлэлтэй байна.

Үндсэн зарчим	Авбал зохих нийт оноо	Авсан оноо	Үнэлгээний хувь	Авах арга хэмжээ
ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	10	83.3%	Баримт бичиг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	10	100%	
Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал	6	4	66.6%	Баримт бичиг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Аудит, хяналтын тогтолцоо	6	3	50%	Шинэчилсэн кодекс нь 2022 онд батлагдсан тул хараат бус аудиторыг Компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Эрсдэлийн удирдлага	8	5	62.5%	Шинэчилсэн кодекст нийцүүлэн эрсдэлийн удирдлагатай холбоотой зарим баримт бичгийг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал	6	5	83.3%	Баримт бичиг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Оролцогч талуудын эрх ашиг	8	7	87.5%	Баримт бичиг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Компанийн соёл	6	5	83.3%	Баримт бичиг шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	7	70%	Компанийн хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийг боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдөнө.
Нэгдсэн дүн	72	56	77.8%	

2022 оны нэгдсэн үнэлгээний хүрээнд Компани нь "Компанийн засаглалын кодекс", түүний зарчмуудыг 77,8%-тай хэрэгжүүлэн ажиллаж, Компанийн засаглал болон соёлыг сайжруулан бэхжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг

тогтмол хэрэгжүүлэв. Цаашид Компани нь өөрийн үнэлгээг тогтмол сайжруулах, шаардлагатай баримт бичгүүдийг олон улсын сайн туршлагад нийцүүлэн шинэчлэхэд анхаарч ажиллах болно.

Хувьцаа эзэмшигчдийн тоо

Анд Системс ХХК	600,000,000
Олон нийт	139,301,683
Халаасны хувьцаа	60,698,317

Хувьцаа эзэмшигчдийн хурал

“ЛэндМН ББСБ” ХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл санхүү, хөрөнгийн зах зээлд шинийг санаачлагч, манлайлагч байсаар ирсэн уламжлалаа хадгалан компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “ХЭЭХ”)–ыг тасалдуулахгүй зохион байгуулах үүднээс COVID-19 цар тахал дэгдсэн нөхцөлд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж 2020, 2021, 2022 онуудад ХЭЭХ-ыг технологийн шийдэл ашиглан “цахим хэлбэр”-ээр амжилттай зохион байгуулж, бусад хувьцаат компаниудыг манлайлан ажилласан билээ.

Компанийн зүгээс Монгол улсын Компанийн тухай хуульд заасны дагуу 2021 оны ХЭЭХ-ыг 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулав. ХЭЭХ-ыг Компанийн

албан ёсны фэйсбүүк хуудсаар шууд дамжуулан хүргэсэн ба саналын эрх бүхий хувьцааны 84.28% буюу 623,059,564 ширхэг хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцоноор тус хурал хүчин төгөлдөр болсон ба дараах асуудлыг хэлэлцэн баталсан юм.

- Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн аудитлагдсан тайланг батлав.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийг улируулан сонгов.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд болон хараат бус гишүүнийг шинээр сонгов.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны төсвийг батлав.

Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн бүрэлдэхүүн



О.БОЛДБААТАР
ТУЗ-ийн дарга
Аудитын хорооны гишүүн
“АНД Глобал” Пти.Лтд-ийн ТУЗ-ийн гишүүн



С.ЭНХ-АМГАЛАН
ТУЗ-ийн гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны дарга
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“Мэргэн инвестмент” Пти.Лтд-ийн ТУЗ-ийн гишүүн



В.БАЯРСАЙХАН
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“Томьёо Эд Тек” ХХК-ийн Ерөнхий захирал



Д.ГАЛХҮҮ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн



С.БОРГИЛ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн
Аудитын хорооны гишүүн
“Сэргэлт Консалтинг групп”-ийн Гүйцэтгэх захирал



Ж.ЖАРГАЛСҮРЭН
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга
“Далайван Аудит” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Б.Хос-Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“АНД Глобал” Пти.Лтд-ийн Гүйцэтгэх захирал
“АНД Системс” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Ц.Ууганбаяр
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүн
“АНД Глобал” Пти.Лтд-ийн Санхүү эрхэлсэн захирал
“ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал



Б.Итгэл
ТУЗ-ийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын хорооны дарга
“АНД Глобал” Пти.Лтд-ийн Гадаад харилцаа хариуцсан Дэд захирал

ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаа

ТУЗ нь компанийн үйл ажиллагааг бэхжүүлэх, зохистой түвшинд удирдах, засаглалын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд, сайн туршлагыг хэрэгжүүлэх, стратегийн зорилтдоо хүрэхэд Компанийг ерөнхий удирдлагаар хангаж, хяналт тавихын зэрэгцээ гүйцэтгэх удирдлагад Компанийн үйл ажиллагааг үр ашигтай, үр дүнтэй удирдахад нь шаардлагатай чиглэлийг өгч ажилладаг.

Компанийн ТУЗ нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд өнгөрсөн нэг жилийн хугацаанд 5 удаа ээлжит, 5 удаа ээлжит

бусаар хуралдан нийт 33 тогтоол гаргажээ. ТУЗ-ийн бүхий л тогтоолуудыг холбогдох журамд заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлээд байна.

ТУЗ-ийг эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 1/ Эрсдэлийн удирдлагын хороо, 2/ Аудитын хороо, 3/ Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Аудитын хороо	Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо (цаашид “ЗНДЦУХ”)	Эрсдэлийн удирдлагын хороо (цаашид “ЭУХ”)
Бүрэлдэхүүн Ж.Жаргалсүрэн (Хорооны дарга) О.Болдбаатар С.Боргил	С.Энх-Амгалан (Хорооны дарга) С.Боргил Д.Галхүү	Б.Итгэл (Хорооны дарга) С.Энх-Амгалан В.Баярсайхан Д.Галхүү Ц.Ууганбаяр Б.Хос-Эрдэнэ

Аудитын хороо нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн дотоод хяналтын тогтолцооны хэрэгжилтэд хяналт тавьж, дотоод аудитын үйл ажиллагааны тайлантай тухай бүр танилцан шаардлагатай санал, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнууд болон Компанийн газар, албадад өгч ажиллалаа. Түүнчлэн, Компанийн зүгээс хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар дүгнэлт гаргах, Компанийн санхүүгийн тайланг баталгаажуулах хөндлөнгийн аудитын байгууллагыг томилох, Компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байлгахад анхаарч мэдээллийг тухай бүр олон нийтэд хүргэж буй эсэхэд хяналт тавьж ажилласан байна.

ЗНДЦУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 3 удаа хуралдаж, ТУЗ-ийн гишүүдийг улируулан сонгох, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг шинээр сонгох асуудлыг хэлэлцэн Компанийн ХЭЭХ-д танилцуулан шийдвэрлүүлэх тухай шийдвэрлэж, мөн Компанийн мөрдөж буй ажлын үр дүнтэй холбоотой урамшууллын системийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад өгч, гүйцэтгэх захирлын томилгоо, гүйцэтгэх захирлын урамшуулалтай холбоотой дүгнэлт гарган ажилласан байна.

ЭУХ нь тайлант жилийн хугацаанд нийт 5 удаа хуралдаж, Компанийн бизнесийн хөгжил, эрсдэл болон эх үүсвэрийн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлох, учирч болзошгүй эрсдэлийг оновчтой удирдан чиглүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нөхцөл байдалтай тухай бүр танилцан хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүдийн ирц, ажилласан хугацаа болон бусад мэдээлэл

ТУЗ-ийн гишүүдийн нэрс	2022 оны ТУЗ-ийн хурлын ирц	ТУЗ-д ажилласан хугацаа, туршлага	Үнэлгээний хувь
О.Болдбаатар	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 5 дахь жилдээ ажиллаж байна.	37,097 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0046%
С.Энх-Амгалан	88.8%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 5 дахь жилдээ ажиллаж байна.	Үгүй
В.Баярсайхан	88.8%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 5 дахь жилдээ ажиллаж байна.	Үгүй
Б.Итгэл	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 1 дэх жилдээ ажиллаж байна.	520 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0001%
Б.Хос-Эрдэнэ	88.8%	ХЭЭХ-аас сонгогдож, 1 дэх жилдээ ажиллаж байна.	Үгүй
Ц.Ууганбаяр	88.8%	ХЭЭХ-аас сонгогдож, 1 дэх жилдээ ажиллаж байна.	18,016 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0023%
Ж.Жаргалсүрэн	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 5 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна.	Үгүй
С.Боргил	100%	ХЭЭХ-аас тухай бүр сонгогдож, 5 дахь жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна.	7,076 ширхэг хувьцаа буюу Компанийн нийт хувьцааны 0.0009%
Д.Галхүү	100%	ХЭЭХ-аас сонгогдож, 1 дэх жилдээ хараат бус гишүүнээр ажиллаж байна.	Үгүй

Компанийн ТУЗ-ийн гишүүд нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржийн холбогдох журам, кодекс, түүнчлэн Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бүр эрхийг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд аливаа шийдвэрийг хараат бусаар, бие даан гаргадаг. ТУЗ-ийн аливаа шийдвэр нь олонхын саналаар хүчин төгөлдөр болдог ба ТУЗ-ийн гишүүн нь хэлэлцэж буй асуудлаар “дэмжсэн”, “татгалзсан”, “түдгэлзсэн”

санал гаргах боломжтой. ТУЗ-ийн гишүүд нь тайлант хугацаанд чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж, хичээл зүтгэл гарган ажилласан гэдгийг ТУЗ-ийн хурлын ирцээс харж болох бөгөөд Компанийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай, ач холбогдолтой шийдвэрүүдийг холбогдох баримт бичиг, судалгаа, тайлбар дүгнэлттэй нэг бүрчлэн танилцсаны үндсэн дээр цаг алдалгүй гаргаж, Компанийн 2022 оны амжилтын голлох хүчин зүйлсийн нэг болсон юм.

ТУЗ-ийн хурлын тогтоол, тэдгээрийн төрөл болон бусад мэдээлэл

Шийдвэр гаргасан огноо	Ирц	Шийдвэр гаргасан хэлбэр	Баталсан тогтоолын тоо
2022 оны 02 дугаар сарын 07	100%	Ээлжит хурал	4
2022 оны 02 дугаар сарын 25	88.8%	Эчнээ санал хураалт	1
2022 оны 04 дүгээр сарын 19	100%	Ээлжит хурал	11
2022 оны 06 дугаар сарын 16	100%	Эчнээ санал хураалт	1
2022 оны 08 дугаар сарын 01	88.8%	Ээлжит хурал	4
2022 оны 09 дүгээр сарын 07	100%	Эчнээ санал хураалт	2
2022 оны 09 дүгээр сарын 13	100%	Эчнээ санал хураалт	2
2022 оны 10 дугаар сарын 20	66.6%	Ээлжит хурал	-
2022 оны 11 дүгээр сарын 22	88.8%	Эчнээ санал хураалт	3
2022 оны 12 дугаар сарын 22	100%	Ээлжит хурал	5

Удирдлага зохион байгуулалт	Санхүү	Эрх олгох	Үйл ажиллагаа	Бизнес стратеги
13	8	4	6	2

Тайлант жилийн хугацаанд Компанийн зээлийн үйл ажиллагааны өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй эрэлтийг хангах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, LendMN 2.0 программ хангамжид шаардлагатай нэмэлт функцуудыг үнэ төлбөргүй

авч ашиглах зорилгын хүрээнд нийт 4 сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн ТУЗ-өөс Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зөвшөөрөл олгосон байна.

ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын мэдээлэл

Компанийн ТУЗ-ийн 2022 оны цалингийн хэмжээ, зарцуулах төсвийг 2022 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан ХЭЭХ-аас баталсан билээ.

ТУЗ нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ба нэмэлтээр шагнал, нөхөн олговор, бусад урамшуулал олгоогүй болно.

Зардлын зүйл	Гишүүдийн тоо	Сарын цалин (төгрөг)	Сар	Нийт төсөв (төгрөг)
Цалин урамшууллын төсөв	10	10,600,000	12	143,100,000
Дарга	1	1,500,000	12	18,000,000
Хорооны дарга	3	1,200,000	12	43,200,000
Гишүүн	5	1,000,000	12	60,000,000
Нарийн бичгийн дарга	1	500,000	12	6,000,000
НДШ-ийн зардал				15,900,000
Хурал болон бусад зардал				10,000,000
НИЙТ ТӨСӨВ				153,100,000

Дотоод аудит

Дотоод аудитын тогтолцоо: “ЛэндМН ББСБ” ХК нь Хамгаалалтын гурван бүс /Three lines of defence/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэн

бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулан ажилладаг.


Дотоод аудитын тогтолцоог харуулбал:



Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар хамгаалалтын бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн

баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороонд тайлагнаж, гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.

КОМПАНИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



“ЛэндМН ББСБ” ХК-ийн удирдлагын баг



Ц.Ууганбаяр
“ЛэндМН ББСБ” ХК
Гүйцэтгэх захирал

“АНД Глобал” Пти.Лтд-д
6 жил ажилласан.



К.Мадоно
“ЛэндМН ББСБ” ХК
Ерөнхийлөгч

Банк, санхүүгийн салбарт
41 жил, “АНД Глобал” Пти.Лтд-д
4 жил ажилласан.



Д.Баасандорж
“ЛэндМН ББСБ” ХК
Бизнес хөгжлийн газрын захирал

“АНД Глобал” Пти.Лтд-д 2 жил,
Банк, санхүүгийн салбарт 2 жил
ажилласан.



М.Түвшинжаргал
“ЛэндМН ББСБ” ХК
Санхүү, үйл ажиллагааны
газрын захирал

Банк, санхүүгийн салбарт
17 жил ажилласан.



М.Бямбасүрэн
“ЛэндМН ББСБ” ХК
Эрсдэлийн удирдлагын газрын
захирал

Банк, санхүүгийн салбарт
13 жил ажилласан.



Г.Золжаргал
“ЛэндМН ББСБ” ХК
Ерөнхий нягтлан бодогч

Банк, санхүүгийн салбарт
13 жил ажилласан.

Гүйцэтгэх удирдлагын цалин урамшууллын мэдээлэл

Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын бодлогын тухай


Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Гүйцэтгэх захирлын цалин, шагнал урамшууллын хэмжээг холбогдох хууль тогтоомж, Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу ЗНДЦУХ-ны хурлаар хэлэлцэн тодорхойлдог бөгөөд шагнал урамшууллын хэмжээг санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтэй уялдуулан жил бүр гаргасан гүйцэтгэлийн үнэлгээний шалгууртай уялдуулан тогтоож,

Гүйцэтгэх захирлын гэрээнд тусган баталгаажуулдаг.

ЗНДЦУХ-ны зүгээс санхүүгийн жил дуусгавар болсны дараа Гүйцэтгэх захирлын тухайн хугацааны үйл ажиллагаа нь Гүйцэтгэх захирлын гэрээнд туссан санхүүгийн болон санхүүгийн бус үзүүлэлтүүдэд хүрч буй эсэх буюу Компанийн жилийн үйл ажиллагааны нөхцөл байдалтай нэг бүрчлэн харьцуулан тодорхойлж, шагнал урамшуулал олгох эсэхийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэх бодлогыг баримталж байна.

Хувьцааны мэдээлэл

Хувьцааны арилжаалагдсан ширхэг болон ханш




Эх сурвалж Монголын Хөрөнгийн Бирж

2022 онд:

- Нийт арилжаалагдсан ширхэг - 8.6 сая ширхэг
- Нийт арилжаалагдсан үнийн дүн - 310.4 сая төгрөг
- IPO хийснээс хойш нийт 295,443,746 ширхэг, 14.6 тэрбум төгрөгийн хувьцаа арилжаалагдсан.
- 2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар компанийн халаасны хувьцаа 60,698,317 ширхэг байна.

Ногдол ашгийн мэдээлэл

Нэгж хувьцаанд зарлагдсан ногдол ашиг (Төг)



“ЛэндМН ББСБ” ХК-ийн Ногдол ашгийн бодлогын дагуу 2022 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 22/03 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.50 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсний дагуу Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг шилжүүлсэн билээ.

Мөн 2023 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн ТУЗ-ийн хурлын 23/09 тоот тогтоолоор “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2022 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.75 төгрөг буюу нийт 1,293,778,000.00 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэлээ.



ВЕБСАЙТ:

www.lend.mn

УТАС:

7707-0101

ИМЭЙЛ:

board@lend.mn

2022 оны жилийн тайланг бэлтгэсэн:
Маркетингийн албаны менежер Б.Батбилэг
Хянасан: Гүйцэтгэх захирал Ц.Ууганбаяр